

## ХҮНИЙ ГАДААД ТӨРХ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХОЧ НЭР

*Р.Нямцэрэн, доктор, Боловсролын хүрээлэн*

### Аннотация

Прозвища есть неотъемлемая часть культурно-исторической жизни монголов, отражающая общий уклад их жизни, специфику бытия, традиций и обычаев, неповторимые особенности национального мышления и социально-исторические условия их существования. Прозвища представляют собой неофициальные, а приобретенные имена, являющиеся универсальным языковым явлением, которые при своём образовании базируются на таких разнообразных источниках, как внешность именуемого, его характер, деяние, принадлежность, род занятий, то или иное произошедшее в жизни событие, любимые слова и фразы, навыки и привычки, имущество, состоятельность и т.д.

Учёные-исследователи антропологии считают, что происхождение имени человека связано с прозвищем, в том числе с прозвищем, связанным с внешним видом человека. Так как лицо и внешний вид человека прежде всего бросаются в глаза тем, с кем он встречается, в жизни существует довольно большое количество прозвищ, связанных именно с этим обстоятельством.

По отборочному исследованию, охваченному почти всю территорию страны, мы зарегистрировали более 6000 имён и прозвищ. Из зарегистрированных нами 1536 устных прозвищ 59,2 процента так или иначе связаны с внешним видом человека. Проведенное нами исследование показывает, что при наделении человека прозвищем, вызванным его внешним видом, исходят из тех или иных специфических особенностей и неадекватной формы не только лица и общего внешнего вида, но и таких, отличающихся от других людей конкретных частей его тела, как голова, волосы, усы, борода, лоб, уши, щеки, челюсти, рот, губы, шея, плечи, руки, ноги, бюст, талия, бёдра и т.д., при этом применяется не только прямое название, но и едкое противопоставление.

Если прямое название бывает ясным для всех той определённой микросферы, то прозвища, которые представляют собой едкое противопоставление, бывают не понятными со стороны сложившейся ситуации, пространства и времени а причина наименования познаётся лишь автором того или иного прозвища. Прозвище, вызванное внешним видом именуемого, имеют положительные и отрицательные оценки, но доминируют прозвища с отрицательной оценкой.

### Түлхүүр үг

Хүний нүүр царай, биеийн ерөнхий төрх байдал, аль нэг эрхтний онцлог шинж, шууд заан нэрлэх, жишин адилсуулах

### Удиртгал

Монгол хүний хоч нэр нь монголчуудын амьдралын хэвшил, аж төрөхүйн онцлог, зан заншил, танин мэдэхүй, үндэсний сэтгэлгээ, нийгэм, цаг үеийн байдлыг тусгаж байдаг түүх, соёлын амьдралын салшгүй хэсэг юм. Хоч нэр нь тухайн хүний гадаад төрх, зан чанар, үйл хөдлөл, хамаа харьяа, эрхэлдэг ажил, тохиолдсон явдал, хэлдэг (хэлсэн) үг, дадал зуршил, эд эдлэл, бэл бэнчин зэргээс нь үүтгэн өгсөн албан бус, олдмол нэр бөгөөд хэлний түгээмэл үзэгдэл мөн.

Бид монгол орны ихэнх нутгийг хамарсан түүвэр судалгаагаар 6000 орчим хоч нэр бүртгэсэн бөгөөд энэхүү аман ярианы 1536 (давхардаагүй тоогоор) хоч нэрийн 59.2% нь хүний гадаад төрх байдлаар нь, 19.6% нь зан араншингаар нь, 4.3% нь их нэрээс нь үүтгэн, 4.0% нь тохиолдсон явдал, хэлдэг (хэлсэн) үгээр нь, 3.9% нь дадал зуршил, хобби, чадвараар нь, 2.73% нь хамаа харьяа,

ажил төрлөөр нь, 2.2% нь хэл яриа, дуу хоолойн онцлогоор нь, 2.0% нь эд эдлэл, бэл бэнчинээр нь тус тус оноож өгсөн байгаа нь монголчууд ихэвчлэн гадаад төрх байдал, зан араншингийн бусдаас ялгарах онцлогоор нь хочлон нэрлэдэг, нийт хоч нэрийн 80 гаруй хувь нь сөрөг үнэлэмжтэй байгаа нь голдуу амьдралын хэм хэмжээ, хүний ерөнхий нийтлэг төрх, ааш араншингийн зүй ёсны харьцаанаас хэтийдсэн байдлаар нь хоч нэр өгдөг гэх үндэстэй байна. Бид энэхүү өгүүлэлдээ хүний гадаад төрх байдалтай холбоотой хоч нэрийг тусгайлан авч үзлээ.

Эрдэмтэн Д.Энхбат “Нэр үүссэн эртний үед анх бие эрхтний хэлбэр, нүүр царай зэргийг онцлон нэрийдэх хоч-нэр үүссэн байна (Энхбат, 2004, х. 43). Өөрөөр хэлбэл, эртний хүмүүсийн нэр анх бие биеэс нь ялгах үүрэгтэй байсан хийгээд хожим нь зан үйлийн (сүсэг бишрэл, зан үйлтэй холбоотой)

үүрэг давхар гарч ирсэн байна” гэжээ. Ийнхүү нэр судлаач эрдэмтэд хүний нэрийн үүсэл нь хоч нэр, тэр дундаа гадаад төрх байдалтай холбоотой хоч нэрээс эхтэй гэж үзэх нь бий.

Монгол хүний хүртэж танин мэдэхүйн сэтгэлгээ илүү хөгжсөн байдаг. Хүний нүүр царай, биеийн төрх байдал нь уулзсан, учирсан бүхний нүдэнд хамгийн түрүүнд тусдаг учир гадаад төрх байдалтай холбоотой хоч нэр нэлээд элбэг болох нь бидний судалгаагаар батлагдаж байгаа юм. Тухайн хүний биеийн хэлбэр, галбир, гадаад төрх байдлаар нь *Алаг нүдэн, Арзгар, Бөгтөр, Бүдүүнээ, Бүлтэн, Ганган, Гулзгай, Данхар, Далиу, Дарвагар, Доголон, Дорвоон, Дутуу, Дух, Дэгжин, Маажиг, Монхор, Мэнгэт, Мээтэн, Навсгар, Нахиу, Нугдгар, Онигор, Оцон, Өргөн, Өндөр, Пандгар, Пэндгэр, Сартгар, Улаанаа, Улцан, Урт гарт, Үрчгэр, Хазгар, Халзан, Хамар, Хожгор, Хув шар, Цоохор, Чөргөр, Шанган, Шарка, Шаамий, Шөвгөр, Эрүү, Ярзгар гэх мэтээр* шууд заан нэрлэж хочилсон байдаг. Шууд заан нэрлэж хочилсон нэр нь тухайн микро орчинд нийтэд тодорхой байдаг онцлогтой.

Гадаад төрх байдлаар нь хочлохдоо дээрхийн адил шууд заан нэрлэхээс гадна эсрэгцүүлэн ёжилж хоч нэр өгдөг байна. Жишээлбэл, Дүрс Болроо (царай муутай, хүний дүрс гэсэн утга), Өндөр Сүрэн (намхан биетэй), Маль цагаан-Гантөмөр (туранхай, хар), Туяхан Согооноо (бүдүүн хадуун) гэх мэт. Энэ нь монголчуудын шооч, наргианч зан чанартай холбоотой агаад тэдний нарийн ажигч, гярхай ухааны илрэл бөгөөд үүссэн нөхцөл, орон зай, цаг хугацааны хувьд бусдад төдийлөн ойлгомжтой бус тухайн бүлэг, хамт олны хүрээнд хочилсон учир шалтгаан нь танигддаг байна.

Мөн гадаад төрх байдлыг нь бусад хүн, юм, үзэгдэл, амьтан, ургамалтай зүйрлэж хоч нэр өгдөг байна. Тухайлбал,

- *Амбий, Ааяа, Ленин, Өндөр Гонгор, Гоймон баатар гэх мэтээр* олны танил хүнтэй,
- *Даамбий, Дональд, Жери, Карлсон, Ким Дун Хан, Кү Унже, Отелла, Өвгөн Басел, Соном өвгөн, Ягаан Гажид гэх мэтээр* киноны баатруудтай,
- *Бөмбөг, Бууз, Мантуу, Данбоали, Асга хад, Барзгар арав, Никель, Бүрхээр, Торх, Гэлийн тамга, Буруу харсан бундан, Прожектор, Гэрлэн дохио, Чийдэн, Камаз, Нүүрс, Өндөг, Поошиг, Гоймон, Саваа, Суран хар, Шүдэнз, Шалны мод, Шонгийн мод, Яндан, Салхи, Шуурга гэх мэтээр* юм, үзэгдэлтэй,
- *Азарга, Алмас, Анааш, Баавгай, Болжмор, Борлон, Боохой, Ботго, Буур, Бүргэд, Бяруу, Галуу, Гахай, Голио, Гөлөг, Гөлчгий, Гутиар, Диназавар, Жараахай, Загас, Зараа, Зулзага, Кошка, Илжиг, Ирвэс, Ишиг, Мазаалай,*

*Мангас, Матар, Мики Маус, Мишка, Монголын шар, Мөөг, Мөндөл, Муур, Огдоолой, Оготно, Ортоом, Сарлаг, Сармагчин, Согоо, Тарган гахай, Тарвага, Тоорой, Турлиах, Тогоруу, Тэмээ, Тэмээн хяруул, Тэмээлзгэнэ, Улаан үхэр, Ухна, Үхэр, Хайнаг, Хув ямаа, Хулгана, Хурга, Хүн хар гөрөөс, Цагаан баавгай, Цоохондой, Чоно, Чөтгөр, Шар муур, Шимпанзе, Шумуул, Элээ, Ялаа, Ямаа, Янзага гэх мэтээр* амьтантай,

- *Газрын бэтэг, Лооль, Лууван, Манжин толгойт, Дэрс, Мөөг, Сонгино, Сондуул, Хурган цагаан мөөг, Шаваг гэх мэтээр* ургамалтай зүйрлэсэн байдаг.

Монголчууд гярхай, нарийн мэдрэмжтэй ард түмэн болох нь хоч нэрийг өгөхдөө хочлуулагчийнхаа хүний нүд, сэтгэлд хамгийн ойр байгаа шинжийг шууд заан нэрлэх, эсрэгцүүлэх, зүйрлэх аргаар өгсөн олон хоч нэрээс харагдаж байна.

Бид цуглуулсан материалдаа үндэслэн гадаад төрх байдлаар нь өгсөн хоч нэрийг дараах байдлаар ангиллаа.

### 1.1 Тухайн хүний нүүр царайн өнгө, төрхөөр нь өгсөн хоч нэр

Алаг Батбаяр, Бор ах, Хар Жигдэн, Улаан Тамираа, Цоохор Цэгмид, Шар Эрдэнэцогт, Шар муур, Шарка (Халиунаа), *Хөх өвөө* гэх мэтээр нүүр царайных нь өнгөөр шууд заан нэрлэж хочилсон байх ба зарим тохиолдолд бусад үндэстний арьсны өнгөөр Сахаар Жигжидсахь, Нигер Баяраа, Орос Нараа гэх мэтээр адилтган, зүйрлэж өгсөн хоч нэр байгаа бөгөөд тэр дотроос судалгаанд хамруулан авч үзсэн бүх аймаг сумдад, бүх насныханд Бор, Улаан, Шар, Хар, Цоохор гэх мэт хоч нэр хамгийн олон давтамжтай байна.

Хөөрхөн Хорлоо, Согоо Сараа, Янзага Бурмаа, Дугуй цагаан (Цэдэндамбаа) гэх мэт хоч нэрийг ажиглавал, хүний хөөрхөн-муухайн жишиг хэмжүүрт үндэслэн тухайн хүний нүүр царайны төрхөөр нь эерэгээр үнэлсэн байна.

Булчирхай шар, Шаржгай, Шаримгар шар, Чалчин Бямбаа, Цаас гэх мэтээр шаримгар, нимгэн царайтай хүнийг, Бубрай, Бумбарцаг, Түнтүү улаан Батболд, Түнтүүл гэх мэтээр махлаг царайтай хүнийг, Түлэнхий Хүрлээ, Бажгар, Барзгар арав, Булдруу Пэлхүү гэх мэтээр нүүрэнд тогтсон өө сэвээр нь хочлон нэрлэсэн ба энэ нь ерөнхийдөө сөрөг үнэлэмжтэй байна.

### 1.2 Тухайн хүний ямар нэг эрхтнийх нь онцлог байдлаар өгсөн хоч нэр

Гадаад төрх байдлаар нь хочлохдоо хүний нүдэнд харагдах эрхтэн тус бүрийн онцлогоос үүтгэн хоч нэр өгсөн байдаг. Тухайлбал, *Биеийн ерөнхий төрх байдлаар нь хочилсон:*

Бусдаас өндөр хүнийг *Анааш Алтай, Гималай,*

*Гозон Болдоо, Гозон тэмээ, Тоомсог Тунгаа, Гоймонбаатар, Шонгийн мод Дууяа, Шаравая, Өндөр Гонгор, Зоолог Золоо, Яндан Цэвэлмаа* гэх мэтээр хочлон нэрлэдэг. Анааш, тэмээ, яндан, шонгийн мод, тоомсог гэх үгийн тэмдгийн утга нь хүний хоч нэр болохдоо өндөр гэсэн утгыг илтгэж байгаа бөгөөд энэ тухай эрдэмтэн Ж.Баянсан “Хэл, соёлын харьцаа хамаарлын асуудалд” өгүүлэлдээ “Тодорхой тэмдэг, ялангуяа хэлний тэмдэг-дохиог зууч болгосон харилцааны тохиолдол болгон нь ямагт “шинэ нээлт” (“эвристично” хэмээн А.А.Леонтьев томъёолсон байдаг) байдаг учраас уг тэмдгийг урьдаас “бэлэн” байгаагаар нь дахин хэрэглэсэн ч гэсэн заавал шинэ агуулга илэрхийлж, утга санааны шинэтгэл болсон байдаг байна” [МУИС, Acta Mongolica, ЭШБ, 2004. 57-р тал.] гэжээ.

Өндрийг илэрхийлсэн Анааш, Гималай, Гозон тэмээ, Гоймон баатар, Шаравая, Шонгийн мод, Яндан гэх мэтээр өөр бусад хүн, юмтай зүйрлэсэн хоч нэр нь Өндөр гэх хочоосоо “илүү өндөр” гэсэн хүч нэмэгдүүлсэн утгатай байна.

Энэхүү хүч нэмэгдүүлсэн утга нь зүйрлэл (метафор) дээр суурилж бүтсэн хоч нэрсэд ихээхэн хамаарах бөгөөд энэхүү хүч нэмэгдүүлсэн утга нь бодит утгын хүчлэл бөгөөд үгийн утгын бүрдүүлбэр болох хэрэглээ зүйд хамаарах яруу утга юм.

Яруу утга, яруу чанарын тухайд судлаачдын дунд ялгаатай ойлголтууд бий. Эрдэмтэн Н.А.Лукьяново “Үгийн яруу утгыг түүнтэй хэмнэл үүсгэх энгийн утгатай үгээр нь тогтоож болно” [Лукьянова Н.А., 1976. с.15.] гэсэн байдаг. Үүнтэй ойролцоо саналыг Т.В. Матвеева дэвшүүлсэн байна. Тэрээр “Яруу утгатай үгийг түүнтэй тэнцэх ойролцоо утгатай энгийн үгэнд тулгуурлахгүйгээр тайлбарлах боломжгүй юм” [Матвеева Т.В., 1986. с.4.] гэжээ.

Монголчууд хэчнээн ажигч, гярхай ард түмэн болохыг бие биеийнхээ онцлог шинжийг маш нарийн ялгамжаатай илэрхийлсэн хоч нэрээс харж болно.

*Гоорон Пүүжээ, Горзгор Цэндсүрэн, Дэрс Сүнжээ, Хорчгор Даймаа, Чөргөр Минжбадгар, Хатсан борц - Дагиймаа, Ямааны гурав, Саваа Номин-Эрдэнэ, Суран хар, Яс Насантогтох гэх мэт хоч нэрс нь өндөр гэхээсээ илүү туранхай гэсэн утгыг; Өөдсөө, Багаа, Богино Бат-Очир, Божин бор, Жогжоохон Батцэцэг, Могжоохон Тулга, Могжоолой, Можиг Оюунтөгс, Төөтгөн, Тоорой Жамбал, Жаал Балдан, Жаахан Дамбий, Жаахнаа, Жижиг Сүхбат, Бозлог Энхбаатар, Одой Сувд, Оготор Галаа, Тайрдас Далхаа, Хожуул Болдоо, Хулгана Мандах гэсэн хоч нэрс нь жижиг, намхан гэх утгыг; Борлон Туяа, Бондгор Буяа, Бондоолой, Бондоохой,*

*Бумбарцаг, Навтгар Санжаа, Паацгар Донров, Пээцэр Наваан, Пагдгар Хаянаа, Пагжгар Идэр, Погжоон Сүрэн, Погдоо Алтанцэцэг, Под Нямсүрэн, Пондгоо, Тарвага Баагий гэх мэт хоч нэр нь намхан, махлаг гэсэн утгыг;*

*Бух Гантөмөр, Гахай Баяраа, Голио Гомбо, Бодон Санжаа, Хайнаг Болдоо, Бүдүүн Раднаа, Бульдозер, Махан Чулуун, Том Сүхбат, Үхэр Жамбаа, Дэндгэр хүүхэн, Дэнхэр Дорж, Үлэмж биетэн Чойжил, Тэнтэг Лавдмаа гэх мэт хоч нэр нь том гэх утгыг;*

*Бандгар Март, Бөндгөр Баяраа, Пандгар Болроо, Памбага, Бөмбөөлэй, Бөөрөнхий, Бандгар Оюун, Хулсны цагаан баавгай, Пэндгэр Хишгээ, Өөхөн Хүрлээ, Махан Сундуй, Поошиг Раднаа гэх мэт хоч нэр нь тарган гэх утгыг;*

*Тогос Чүлтэм, Донж Дулмаа, Шанган Дулмаа, Супер Оюун, Жавхаалаг Оюун гэх мэт хоч нэр нь гоё, сайхан гэсэн утгыг;*

*Өвгөн Болдоо, Чавганц Өсөхөө, Үлхээн Батаа, Мануухай Дэмчигдорж, Хүүхэн Төрөө, Бээвгэр Уран, Навсаан Дорж, Навсгар Бүрнээ, Гонжгор Ариунаа, Туниа муут Хүрэлчулуун гэх мэт хоч нэр нь дорой, сул гэсэн утгыг тус тус илэрхийлж байна.*

*Толгойн байдал, төрхөөр нь хочилсон:*

Толгойн байдал төрхөөр хочлохдоо *Данхар Түмээ, Дагз Даваа, Вагон Толгой Гансүх, Морин толгой Балжаа, Хойшоо толгойт Жаргалсайхан, Том толгой Чойжинжав, Тунхуу толгойт, Туйний толгойт, Манжин толгойт, Мандарин толгойт, Тарвас толгойт гэх мэтээр* толгойн том байдлаар нь; Гээдэн Батмөнх, Далбин Сүхээ, Дальжгар Өлзий, Түнжиг Баяраа гэх мэтээр толгойн хэвээр нь; Махан толгой Бадам, Ясан толгой Гүрээ гэх мэтээр толгойн туранхай-махлаг байдлаар нь хочилсон нарийн ялгамжааг илэрхийлсэн байдаг. Эдгээр хоч нэр нь толгойн хэлбэр, том-жижгийн ялгамжийг нарийн тусгаж, шууд заан нэрлэснээс гадна бусад эд, юмтай жишин адилсуулж, зүйрлэж нэрлэсэн, шилжсэн утгатай байна.

*Үс, сахлын байдлаар нь хочилсон:*

*Буржаак, Буржгар Цэлмэг, Долгионоо (буржгар үстэй), Каракул Банзрагч, Пүдэл (буржгар үстэй нохой) Туул, Зиг заг гэх мэтээр үснийх нь хэвийн буржгар байдлыг;*

*Дэлт Сүхээ, Дэрэнгийн хар азарга, Сэгсгэр Чимэддорж, Урт үст Цэрэнпил, Үст хар, Гээг Очироо, Гээгт Хүрлээ, Гээгтэй Цагаан Төмрөө гэх мэт хоч нэр нь үс урттай, үс ихтэй гэсэн утгыг;*

*Мулзан Энхбаатар, Халзан Ганболд, Цөөхөн үст, Хүйх Чойсүрэн, Хожгор Баяраа, Гялаан Чулуунбат, Ленин гэх мэт хоч нэр нь үс цөөтэй,*

халзан гэсэн утгыг;

Буурал Ганаа, Цагаан үст Ганболд, Шар толгой Энхээ, Шараа, Загал толгойт гэх мэт хоч нэр нь үсний өнгийг заасан утгыг тус тус илэрхийлжээ. (Мөн хамаа харьяа, гадаад төрх байдлыг давхар илэрхийлсэн Алтайн арзгар, Заалны загал толгойт (биеийн тамирын баги) гэх мэт хоч нэр бидний судалгааны санд байна.)

Арзгар Адъяа, Туужуур толгой Пүрвээ, Гороосон толгойт, Паанк Эрка, Пинтүү Лхүндэв, Халимаг Цогоо, Сорлог Сүнжээ гэх мэтээр үсний самналт, арчлалт, тухайн цаг үеийн үсний засалт гэх мэт соёлын талаас нь ч харж хочилсон байна.

Мөн Бавгар Шагдар, Сахал Амраа, Сахалт Ванчигжав, Ширвээ хар Пүрэв, Ээтэн годон гэх мэтээр сахлаар нь хочлон нэрлэсэн байдаг.

Ихэнх хоч нэр нь шууд заан нэрлэсэн, зүйрлэн шоглож шоодсон утгатай байгаа бол Сөөвгөр Шагтай, Сөөвөн, Сөөсгөр Ану, Сөөсөг Нямаа, Оонолжий (үсээ ооны эвэр шиг 2 салаа боосон байдлаас нь өгсөн) гэх мэт өхөөр хоч нэр байна.

Архангай аймгийн ЗДТГ-ын жолооч нар Халзан Чука хочтой даргаа сэгсэлзээд хэмээн эсрэгцүүлэн ёжилж “За цаадах чинь одоо сэгсэлзээд л ороод ирнэ шүү” хэмээн шоглон ярьж суухыг сонсвоос монголчууд хэчнээн шооч, ёжит хүмүүс болох нь харагдаж байна.

Духны байдлаар нь хочилсон:

Дух Равдан, Атираа Бэгз, Үрчгэр Далхаа, Үрчээхэй, Халзан Айнаа, Халздай, Эрэг духт, Том духт, Мэлгэр хүүхэн гэх мэтээр шууд дүрслэн нэрлэсэн хоч нэр байна.

Нүдний төрх, түүний зарим эмгэг согоогоор нь хочилсон:

Ботго Шүрээ, Алаг нүдэн Цоом, Хар нүдэн Хандаа, Бүлтгэр, Бүлтүүш, Дүрлэгэр Баатар, Тугалан нүдэт, Эрээн хүүхэн, Хөмсөг Жаанаа, Сормуус Алтай гэх мэтээр том, хөөрхөн, хүний сэтгэлд таатай утгыг илэрхийлсэн бол Оргоом Бүжээ гэхэд ортоом үхрийн нүд шиг том, гэхдээ улаанаар эргэлдсэн, хүний сэтгэлд таатай бус утгыг илэрхийлжээ. Том нүднээсээ алаг нүд, хар нүдийг монголчууд ихэд өхөөрддөг ажээ. Хүүхдийн хувьд бүлтгэр нүд нь хөөрхний хэмжүүр болж эерэг үнэлэмжийг илэрхийлж байна.

- Нүдний жижиг, онигор шинжээр нь нэрлэсэн Жонго Даваасүрэн, Жоонон Галаа, Онин Думаа, Онин бууз, Ониго Балсан, Сүүмэн Жагаа, Улцан Хайдав, Нүд Сэнжинбавуу гэх мэт;

- Нүдний өнгөөр нь нэрлэсэн Хар нүдэн Хандаа, Гэрлэн дохио, Ногоон Баяраа, Ногоон муур, Прожектор Бажсаа гэх мэт;

- Нүдний хөдөлгөөнийг дүрслэн хочилсон Анингаа, Анивчаа Батаа, Анивчдаг шар, Гөлөөн

Даваасүрэн, Диско Батбаяр, Ирмэдэг бор гэх мэт; - Зовхины байдлаар нь хочилсон Булцэн Жагдал, Улцан Хайдав, Домбон ётон, Хялман Сараа гэх мэт;

- Нүдний харааны эмгэгээр нь хочилсон Долир Сүрэн, Солир Даваа, Сохор Адъяа, Бүрхэг Наваан (хараа муутай), Хараагүй Хандаа, Хялар Энхээ, Очки Жамъянжав мэт хоч нэрс нь доромж найруулгатай, хүний эмгэг байдлыг шоглож шоодсон өнгө аястай байна.

Чихний байдлаар нь хочилсон:

Далбаан хар, Далбин шар, Далбин Сүхээ, Дэлдүүш, Дэлдэн Бадарч, Дэлдээхэй зэрэг хоч нэр нь том, Навчин чихт Мөнхсайхан, Даамбий, Дэрчгэр шар, Дэлбээ гэх мэт хоч нэр нь том, нимгэн гэсэн утгыг,

Хув Цэрэндорж, Хув улаан (Батсуурь), Хулгар шар, Хулгар Ядам, Хумбаанай (Доржсэмбэ), Хумбаан хар (Улсын арслан Балсан), Хумбаарай, Хумбага, Хумбал (Баянжаргал), Хумбан гэх мэт хоч нэр нь хумбан гэсэн утгыг заан хочлон нэрлэсэн байдаг.

Мөн чихэндээ молцогтой бол Гурван чихт Азаа, Гурваа, Молцог гэх мэтээр хочилдог. Боовон чихт гэх хоч нэр нь бөхчүүдийн чихэндээ авсан гэмтлээс нь үүдэлтэй ч энэ нь бөхчүүдийн хүрээнд нийтлэг үзэгдэл учраас төдийлөн ингэж хочлохгүй, харин ард иргэдийн дунд бол хоч нэр болдог байна.

Хамрын байдлаар нь хочилсон:

Бариул (бариад авмаар том хамартай), Дамар Дамчаа, Хамар Отгоо, Мондгой хамарт (Бат-Ирээдүй), Муна хаанжий гэх мэт том хамартай; Хамаргүй Пунцаг, Нарьмаан Рэнцэндорж, Намшаанаа, Намалдаг Жагаа, Нахиу Санжсүрэн гэх мэт жижиг, нармигар хамартай;

Разетка Анхбаяр, Онгорхой хамарт, Сартгар Нараа, Сархаан Батаа гэх мэт сархагар хамартай; Шантаанаа, Шантгар Догоо гэх мэт шантгар хамартай;

Мээтэн Аюур, Янтгар Должоо гэх мэт мээтгэр хамартай;

Буратино, Харандаан хамарт, Шонхор Шарав, Шонх Даймаа, Шонтгор Болор, Шонтоон, Шонтууз, Шонхоон, Шонхоодой Уран гэх мэт шонтгор хамартай;

Монхоодой Оюунтөгс, Монхор Пүрэвragчаа, Монхор хамарт Гэрэл, Монхоорой, Монхууз Алтангэрэл гэх мэт монхор хамартай гэсэн утга бүхий хамрын хэлбэрээр нь хочилсон нэр байна.

Мөн Нус Азаа, Бурантаг, Нусан бурантаг, Нусгай, Нууяа Жагаа, Таглаа Шинээ, Таглаа хамар (Даваажав), Улаан хамарт Баяраа гэх мэтээр хамрын эмгэг согоогоор нь хочилсон байдаг.

*Хацар, шанаа, түүшний байдлаар нь хочилсон:*  
 Бидний судалгаанд хацрын өнгө, төрх байдлаар нь нэрлэсэн Улаан хацарт Нямаа, Цунцуу Мандаа, Цунцага Мэндээ гэх мэт шууд заан нэрлэсэн хоч нэр, Алимаа, Алимхан, Борви Батаа, Бундан хацарт, Даалин хацарт гэх мэт зүйрлэсэн хоч нэр, шанаа, түүшний байдлаар шууд заан нэрлэсэн Түүш Жагаа, Хүрэн шанаат Урнаа гэсэн цөөн хэдэн хоч нэр бүртгэгдсэн байна.

*Эрүү, ам, уруулын байдлаар нь хочилсон:*  
 Дарваан Батаа, Дорвоон Болдоо, Сэт Амраа, Сэтэрхий Дорж, Умгар Мандах, Тэмээн уруулт, Шазаалай, Шазан Баясгалан гэх мэтээр уруулын байдлаар, Вампир, Эксковатор (үүдэн шүд нь эксковаторын шанага шиг урагшаа) Энхбат, Буйл Цэрэндорж, Соёо, Цус сорогч гэх мэтээр шүд, буйлны хэсэг нь урагш түрсэн, соёотой хүнийг; Шаамий Цэрэн, Шаймгар шар, Эрүү Гонгор, Яажгий эрүү Шинэцэцэг гэх мэтээр эрүүний байдлаар нь өгсөн хоч нэр байгаа бөгөөд эдгээр нь ихэвчлэн сөрөг үнэлэмжтэй, шоглож шоодсон утгатай байна.

*Хүзүүний байдлаар нь хочилсон:*  
 Галуун хүзүүт (урт, өндөр хүзүүтэй), Гогор (гоохгор) Дорлиг, Гооргор Төвшөө, Гоорон Пүүжээ, Гилжгий Норовдаш, Хар хүзүү Дагий, Улаан хүзүү Дэлэг гэх мэтээр хүзүүний бусдаас ялгарах онцлог, эмгэг согоогоор нь ялган хочилсон байна.

*Мөр, дал, цээжний байдлаар нь хочилсон:*  
 Бөгтөр Санчин, Нугдгар Түмээ, Хавтгай Сараа (хавтгай цээжтэй), Шувуун цээж Хүрлээ, Хавхаг Балжинням (хавхагар, том цээжтэй), Эрээн хавиргат Төрбат (хавирган дээрээ мэнгэтэй, том хавиргатай бөх байсан), Хүрз Санжаадамба (цээжиндээ бяртай, дайрч, давшилж барилддаг)

гэх мэт хоч нэр байна.  
*Бэлхүүс, өгзөгний байдлаар хочилсон:*  
 Хүний бэлхүүсний хэсгийн байдлаар Гүзээ Гонгор, Гүзээн Гүмбэ, Цоц (цоцгор) Ганбаа, Цондоолой, Цэндгэр Ану, Цүндээхээ, Уухай туухай баатар, Ууцан дундуураа тасархай баатар; өгзөгний хэсгийн байдлаар Амбаар Должоо, Банз Баясгалан, Бөгс Дууяа, Бөгсбаатар, Женипер, Оцон Ганаа, Тонтоолой, Тонтоохой, Тонтоон Мягмар, Шувтан Жагаа, бэлхүүс, өгзөгний байдлыг хамтатган Буруу харсан бундан, Гэлийн тамга гэх мэтээр хочилсон байна.

*Гар, хуруугаар нь хочилсон:*  
 Солгой Ойдов, Гар Тэнгис (бусдаас урт гартай), Тахир Мандах (тахир гартай), Арван нэгэн хуруу Баасан, Зургаан хуруу Дэмид, Зургаадай, Илүү, Дутуу Санжаа, Мөөтөг Дулам (хуруугүй), Мухар Батаа (гаргүй) гэсэн хоч нэрс байгаа нь гар хурууны бусдаас ялгарах онцлог, гэгэг согоогоор нь шууд заан нэрлэхээс гадна зүйрлэн нэрлэж, шоглосон, шоодсон утгатай байна.

*Хөлийн байдлаар нь хочилсон:*  
 Майжиг Лхагваа, Майга Ганбаа, Доголон Равдан, Доёг Болдоо, Дойдон Сүх, Майргар Анхаа, Сайргар Саянлхам, Паацгар Донров (богино хөлтэй), Малтуур Мөнхөө, Мод Баяраа (модон хөлтэй), Хөлгүй Ооноо гэх мэт хоч нэр байгаа нь шууд заан нэрлэхээс гадна зүйрлэж нэрлэн хөлийн хэлбэр, эмгэг согогийг шоглож шоодсон утгатай байна.

Бидний бүртгэсэн аман ярианы 1536 (давхардаагүй тоогоор) хоч нэрийн 909 нь буюу 59.2 % нь хүний гадаад төрх байдалтай холбоотой байна.

График 1



График 2



Гадаад төрх байдалтай холбоотой 909 хоч нэрийн 531 нь буюу 58.40% нь шууд заан нэрлэсэн утгатай, 5 нь буюу 0.55% нь эсрэгцүүлж ёжилсон утгатай, 373 нь буюу 41.03% нь шилжсэн утгатай байна.

Шилжсэн утгатай буюу зүйрлэл (метафор)-ээр бүтсэн 373 хоч нэрийн 151 нь буюу 40.48% нь ямар нэгэн юм, түүний шинж байдалтай, 133 нь буюу 35.66% нь амьтантай, 72 нь буюу 19.30% нь олны танил, алдартай хүн, кино, зохиолын баатартай, 17 нь буюу 4.56% нь ургамалтай тус тус зүйрлэсэн хоч нэр байна.

## Дүгнэлт

Хоч нэр нь тухайн хүний гадаад төрх, зан чанар, үйл хөдлөл, хамаа харьяа, эрхэлдэг ажил, тохиолдсон явдал, хэлдэг (хэлсэн) үг, дадал зуршил, эд эдлэл, бэл бэнчин зэргээс нь үүтгэн өгсөн албан бус, олдмол нэр бөгөөд хэлний түгээмэл үзэгдэл мөн.

Хүний нүүр царай, биеийн төрх байдал нь уулзсан, учирсан бүхний нүдэнд хамгийн түрүүнд тусдаг учир гадаад төрх байдалтай холбоотой хоч нэр аман ярианы хоч нэрийн дотор эзлэх хувь хамгийн өндөр байгаа бөгөөд ийнхүү хочлохдоо тухайн хүний биеийн хэлбэр, галбир, гадаад төрх байдлаар нь хүний нүд, сэтгэлд хамгийн ойр байгаа шинжийг шууд заан нэрлэж хочлохоос гадна эсрэгцүүлэн ёжилж, бусад хүн, юм, үзэгдэл, амьтан, ургамалтай зүйрлэж хоч нэр өгдөг байна.

## Ашигласан материал

- Бадамдорж, Д. (2006). *Монгол хэлний үгсийн сангийн утга зүй. Улаанбаатар*
- Бадамноров, Д. (2000). *Монгол хүний хоч нэрийн утгын тухай, МУИС-ийн Ховд дахь салбар сургууль, Эрдэм шинжилгээний ойллого, II боть XVI дэвтэр. Улаанбаатар*
- Баянсан, Ж. (1996). *Зүйрлэл бол танин мэдэхүй, сэтгэлгээний онцлогийн тусгал болох нь. МУИС, МСДС, ЭШБ, Улаанбаатар*
- Баянсан, Ж. (2002). *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, Улаанбаатар*
- Баянсан, Ж. (2004). *“Хэл, соёлын харьцаа хамаарлын асуудалд. МУИС Аста Mongolia, Улаанбаатар*
- Бямбасан, П. (1969). *Оноосон нэрийн тухай. Хэл зохиол судлал, II боть, Улаанбаатар*
- Лукьянова, Н.А. (1976). *О соотношении понятий экспрессивность, эмоциональность, оценочность /Актуальные проблемы лексикологии и словообразования. Вып.5. Новосибирск.*

- Матвеева, Т.В.(1986). *Лексическая экспрессивность в языке. Свердловск*
- Нансалмаа, Н. (2004). *Орчин цагийн монгол хэлний хоч нэрийн бүтэц, утгазүйн онцлог. МУИС. МХСС, Монгол судлал, ЭШБ, 23-р боть, 9-р дэвтэр, Улаанбаатар.*
- Энхбат, Д. (2004). *Хүмүүний зохист нэр, Улаанбаатар*